

**2018 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт, техник эдийн засгийн үзүүлэлтийн дүн, түүнд хийсэн шинжилгээ**

**1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**1.1 Цахилгаан эрчим хүч түгээлт**

Тус компани 2018 онд 1085.0 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 179.5 сая кВтц буюу 16.54 %-ийг зарцуулан 905.5 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээж анхны төлөвлөгөөг 105.1 %-аар биелүүллээ. Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчний 98.3%-ийг “ДҮТ” ХХК-д, 0.6%-ийг өөрийн шиний түгээлт, 1.1%-ийг үйлдвэрлэлийн бус хэрэглээнд тооцогдсон энерги тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд түгээсэн цахилгаан эрчим хүчийг төлөвлөгөөтэй харьцуулахад 44.3 сая кВтц-аар буюу 5.1%-иар, өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3.6 сая кВтц-аар буюу 0.4 %-иар тус тус нэмэгдсэн байна. Тайлант хугацааны цахилгаан эрчим хүчний үзүүлэлтүүдийг төлөвлөгөө болон өмнөх онтой харьцуулан хүснэгт №1-д үзүүллээ.

Хүснэгт №1

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Зөрүү		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	гүйц-төл	гүйц-өм.он	
Дундаж цахилгаан чадал	МВт	123.0	118.3	<b>123.9</b>	5.5	0.8	
Цахилгаан эрчим хүч боловсруулалт	сая кВтц	1077.7	1036.5	<b>1085.0</b>	48.6	7.3	
Нийт түгээлт		901.9	861.3	<b>905.5</b>	44.3	3.6	
ЦДҮС-д түгээсэн		889.9	849.2	<b>890.4</b>	41.2	0.5	
Өөрийн түгээлт		Шинээс	4.5	3.8	<b>5.1</b>	1.3	0.7
		Үйлд.бус	0.6	0.5	<b>0.8</b>	0.3	0.3
		Транс.алд	7.0	7.7	<b>9.1</b>	1.4	2.1
		Нийлбэр	12.0	12.1	<b>15.1</b>	3.0	3.1

**1.2 Дулааны эрчим хүч түгээлт**

2018 онд 4209.4 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн, уураар 282.5 мянган Гкал, усаар 1910.2 мянган Гкал, нийт 2192.7 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж анхны төлөвлөгөөг усаар 94.2%, уураар 112.1%, нийт дулаан түгээлтийг 96.2%-аар биелүүлж ажиллалаа. Тайлант хугацааны дулааны эрчим хүчний түгээлтийг төлөвлөгөө болон өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан хүснэгт №2-д үзүүллээ.

Хүснэгт №2

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Зөрүү			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	гүйц-төл	гүйц-өм.он		
1	Усаар	УБДС ТӨХК	мян.Гкал	1899.7	2024.9	<b>1908.0</b>	-116.9	8.3	
2				Өөрийн түгээлт	2.1	2.2	<b>2.2</b>	0.0	0.1
3				Нийт	1901.8	2027.1	<b>1910.2</b>	-116.9	8.4
4				Уураар	261.2	252.0	<b>282.5</b>	30.5	21.3
5				Нийт	2163.0	2279.1	<b>2192.7</b>	-86.4	29.7

“УБДС” ТӨХК-нд түгээсэн дулааны эрчим хүч төлөвлөгөөнөөс 116.9 мянган Гкал-аар буурч, өмнөх жилийн гүйцэтгэлээс 8.3 мянган Гкал-аар нэмэгдсэн байна. УБДС-д түгээсэн дулааны үзүүлэлтүүдийг хүснэгт №3-д үзүүлээ.

Хүснэгт №3

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгж	2017 он	2018 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-тел	Гүйц-өм.он
Сүлжээнд өгсөн дулаан	мян.Гкал	1899.7	2024.92	<b>1908.02</b>	-116.9	8.32
Нэмэлт усны зарцуулалт	тн/ц	170.3	185.5	<b>183.0</b>	-2.5	12.7
Сүлжээний усны дундаж зарцуулалт	тн/ц	6366	6968	<b>6411.3</b>	-556.7	45.3
Усны халалт	градус	49.4	46	<b>49.5</b>	3.5	0.1
Шууд усны халуун	градус	101.5	98	<b>102.4</b>	4.4	0.9
Буцах усны халуун	градус	52.1	52	<b>52.9</b>	0.9	0.8

Дээрх хүснэгтээс харахад төлөвлөгөөнөөс сүлжээний усны зарцуулалт 556.7 тн/ц-аар, халалт 3.5 °С-ээр буурсан нь дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөө 116.9 мянган Гкал-аар буурахад нөлөөлсөн байна.

Уураар түгээсэн дулааны эрчим хүчний үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулан хүснэгт №4-д үзүүлээ.

Хүснэгт №4

Он	Үйлдвэрийн уурын			Уураар түгээсэн дулаан Гкал	Ажилласан үйлдвэрийн тоо (дунджаар)	Хуваарилалтын хувь
	Даралт ата	Халуун градус	Зарцуулалт тн/ц			
2014 он	9.3	307	39.3	249935	62	75,9
2015 он	9.4	308	37.9	243089	61	73.4
2017 он	9.4	309	40.8	261178	68	75.25
<b>2018 он</b>	<b>9.1</b>	<b>301</b>	<b>44.5</b>	<b>282475</b>	<b>75</b>	<b>76.59</b>
зөрүү	-0.3	-8	3.7	21297	7	1.34

2018 онд уураар 282.5 мянган Гкал дулааны эрчим хүч түгээсэн нь төлөвлөгөөнөөс 30.5 мянган Гкал-аар, өмнөх жилийн гүйцэтгэлээс 21.3 мянган Гкал-аар тус тус өссөн байна. Үүнд ДЭХ хэрэглэгчийн тоо өссөнөөр уурын зарцуулалтын хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### 1.3 Диспетчерийн графикийн биелэлт

2018 онд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөөг цахилгаан эрчим хүчинд 100.5% дулааны эрчим хүчинд 100% биелүүлж ажиллалаа. Диспетчерийн графикийн нэмэх шийдвэрээр 6808.3 мянган кВтц цахилгаан эрчим хүч илүү, хасах шийдвэрээр 1823.7 мянган кВтц цахилгаан эрчим хүч бууруулан үйлдвэрлэж диспетчерийн графикийн төлөвлөгөөг 4735.0 мянган кВтц-аар давуулан биелүүлсэн байна.

Диспетчерийн графикийн нэмэх, хасах зөрчил болон шийдвэрийг өмнөх онтой харьцуулан график №1-д харууллаа.

### Диспетчерийн график мян.кВтц

График №1




Диспетчерийн графикийн биелэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад нэмэх шийдвэр 1995.5 мян.кВтц-аар, хасах зөрчил 524.2 мян.кВтц-аар, нэмэх зөрчил 9.5 мян.кВтц-аар тус тус нэмэгдэж, хасах шийдвэр 760.2 мян.кВтц-аар буурсан байна.

Диспетчерийн графикийн хасах зөрчлийг холбогдох нэгжээр ангилан дараах графикт харууллаа.

Диспетчерийн графикийн хасах зөрчил, мян.кВтц

График №2



Дээрх графикаас харахад ӨДЗ цех болон ӨДТ цехээс шалтгаалсан хасах зөрчлийн хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн байна. Мөн гадны компаниас шалтгаалсан хасах зөрчлийн хэмжээ нь нийт зөрчилд 43.2%-ийг эзэлж байна. Эдгээрийн талаар дэлгэрэнгүй авч үзье.


ӨДЗ, ӨДТ цехүүд болон гадны компаниас шалтгаалсан хасах зөрчлүүдийг өмнөх онтой харьцуулан авч үзлээ.

ӨДЗ цехийн хасах зөрчлийн шалтгаан, мян.кВтц

График №3



Графикаас харахад түүхий нүүрс тэжээгчийн гэмтэл өссөн болон ШБМ-ын гэмтэл, хурц уурын халуун буурснаас ТГ зогсоосон, нүүрсний чанар муу зэргээс шалтгаалсан гэмтлүүд шинээр нэмэгдсэн нь өмнөх оноос нэмэгдэхэд нөлөөлсөн байна.



2018 онд ТГ №9 их засвар хийгдсэн. Үүнтэй холбоотойгоор их засвараас явуулах ажиллагааны үед 400.5 мян.кВтц хасах зөрчил гаргасан байна. Мөн тэжээлийн усны хүйтэн тэжээгч №1-ын хаалтны гэмтэл устгах үед 210.3 мян.кВтц-ын хасах зөрчил гаргасан зэрэг нь өмнөх оноос хасах зөрчил нэмэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Засварын цехээс шалтгаалсан хасах зөрчил 2017 онд гарч байгаагүй бол 2018 онд дараах хасах зөрчлүүд гарсан байна.

Он/сар/өдөр	Зөрчлийн шалтгаан	Зөрчлийн хэмжээ (мян.кВтц)
2018/06/12	ТГ №7-ын генераторын хөргөлтийн шугамд үлээлт гарсан.	77.6
2018/09/04	ТП 4 трансформаторын кабель гэмтэж зуух №11 зогссон.	12.4
2018 он	Нийт	90.0

Гадны компаниас шалтгаалсан хасах зөрчлийн хэмжээ өмнөх оноос 33 мян.кВтц-аар буурсан боловч нийт хасах зөрчлийн 43.2%-ийг эзэлж байна. 2018 онд гадны байгууллагаас шалтгаалсан хасах зөрчлийг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт №5

Он/сар/өдөр	Зөрчлийн шалтгаан	Зөрчлийн хэмжээ (мян.кВтц)
2018/09/04	ТП 4 трансформаторын кабель гэмтэж зуух №11 зогссоноос	12.4
2018/09/15	Хүчдэлийн савлалтаас ДДС болон ӨДС "0" зогссон.	488.7
2018/09/19	Хүчдэлийн савлалтаас ӨДС "0" зогссон.	370.4
2018/12/08	Зуух №8-н "Б" ПСУ-ны гинж тасарч зогссон	25.3
2018 он	Нийт	896.8

Хасах зөрчлийг спот болон импортын зөрчлөөр ангилан өмнөх онтой харьцуулан хүснэгт №5-д харууллаа.

Хүснэгт №6

Он	СПОТ мян.кВтц	Импортын зөрчил мян.кВтц	Нийт хасах зөрчил мян.кВтц
2017 он	706.3	842.8	1549.1
2018 он	760.9	1312.4	2073.3
Зөрүү 2018-2017	54.6	469.6	524.2

СПОТ зах зээлд худалдсан болон худалдан авсан цахилгаан эрчим хүч, мөнгөн дүнгийн хэмжээг хүснэгт №6-д харууллаа.

Хүснэгт №7

№	Станцууд	Худалдсан спот		Худалдан авсан спот		- өглөг , + авлага (мян.төг)
		Цахилгаан энерги мян.кВтц	Мөнгөн дүн мян.төг	Цахилгаан энерги мян.кВтц	Мөнгөн дүн мян.төг	
1	ДЦС-4 ТӨХК	1658.3	5223.6	626.6	1973.8	3249.8
2	ДЦС-2 ТӨХК	27.5	1131.5	31.9	1313.7	-182.2
3	ДДЦС ТӨХК	14.2	277.8	34.3	673.1	-395.3
4	ЭДЦС ТӨХК	4.2	70.9	13.5	228.6	-157.7
5	Ухаа худаг	46.3	7066.5	9.9	1511.4	5555.1
6	ЭҮДЦС	117.7	10779.8	44.6	4087.8	6692.0
7	Нийт	1868.2	24550.2	760.9	9788.3	14761.9

СПОТ зах зээлээс 706.9 мянган кВтц цахилгаан эрчим хүчийг 9.8 сая төгрөгөөр худалдан авч, 1868.2 мянган кВтц цахилгаан эрчим хүчийг 24.6 сая төгрөгөөр худалдан СПОТ зах зээлд 14.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## 2. ОРЦЫН ШИНЖИЛГЭЭ

### 2.1 Түлшний зарцуулалт

2018 онд нийт 1325.1 мянган тонн нүүрс, 863.5 тонн мазут, 18099 литр солярка зарцуулж оны эцэст 67.4 мянган тонн нүүрс, 555.8 тонн мазут, 6150 литр солярканы нөөцтэй байна.

#### 2.1.1 Нүүрс

2018 онд Багануурын уурхайгаас 20376 вагон буюу 1331.5 мянган тонн нүүрс нийлүүлэгдсэн ба энэ нь өмнөх жилийн гүйцэтгэлээс 37.3 мянган тонноор, уурхайтай байгуулсан гэрээнээс 31.5 мянган тонноор тус тус өссөн байна. Нүүрсний дундаж илчлэг 3548 ккал/кг, үнслэг 8.7%, чийглэг 35.52% байлаа. Энэ нь өмнөх онтой харьцуулахад дундаж илчлэг 54 ккал/кг-аар, үнслэг 0.56%-аар тус тус буурч, чийглэг 1.14 %-иар өссөн байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 1325.1 мянган тонн, хадгалалтын хэвийн хорогдлоор 0.7 мянган тонн, ахуйд 10.3 мянган тонн, үйлдвэрлэлийн бус хэрэглээнд 28.0 тонн нийт 1336.2 мянган тонн нүүрс зарцуулсан байна. Нүүрсний зарцуулалтын хэмжээг төлөвлөгөө болон өмнөх онтой харьцуулан хүснэгт №8-д харууллаа.

Хүснэгт №8

Үзүүлэлт	Нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төл-гүйц	гүйц-өм.он
Нүүрсний зарцуулалт	мян.тонн	1275.4	1386.9	1325.1	-61.8	49.7

2018 онд 1325.1 мянган тонн нүүрс эрчим хүч боловсруулахад зарцуулсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 61.8 мянган тонноор буурч, өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 49.7 мянган тонноор нэмэгдсэн байна. Нүүрсний зарцуулалтын хэмжээ буурсан шалтгааныг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт №9

№	Үзүүлэлт		ΔЦЭХ-д	Δ ДЭХ-д	Δ Бүгд
1.1	Жишмэл түлшээр	Төлөвлөгөөний хазайлтаас	13561.6	-15136.3	-1574.7
1.2		ЖТХЗ-ын хэмнэлтээс	7565.1	-84.7	7480.4
1.3		<b>Нийт</b>	21126.7	-15221.1	5905.6
2.1	Бодит нүүрс	Төлөвлөгөөний хазайлтаас	44.3 сая.кВтц	-86.4 мян.Гкал	-3302.0
2.2		ЖТХЗ-ын хазайлтаас	8.22 гр/кВтц	-0.01 кг/Гкал	14809.1
2.3		Илчлэг нэмэгдсэнээс	+242 ккал/кг		-73268.1
2		<b>Нийт</b>			-61761.0

### 2.1.2 Шингэн түлш

2018 онд эрчим хүч боловсруулахад 863.5 тонн мазут зарцуулсан нь анхны төлөвлөгөөнөөс 86.5 тонн мазут хэмнэж ажилласан байна. Мазут зарцуулалтын хэмжээг төлөвлөгөө болон өмнөх онтой харьцуулан хүснэгт №10-д харууллаа.

Хүснэгт №10

Үзүүлэлт	Нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төл-гүйц	гүйц-өм.он
Мазутын зарцуулалт	Тонн	871.1	950	863.5	-86.5	-7.6

Мазут зарцуулалтыг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулан хүснэгт №11-д харууллаа.

Хүснэгт №11

№	Мазут түлсэн шалтгаан	2017 он	2018 он	Зөрүү	Эзлэх хувь (%)
		Тонн			
1	Хүйтэн галлагаа	556.5	<b>484.7</b>	-71.8	56.1%
2	Тоосон систем сэлгэх	68.1	<b>100.6</b>	32.4	11.6%
3	МВ, ШБМ доголдож	68.8	<b>56.2</b>	-12.7	6.5%
4	Халуун галлагаа	36.9	<b>47.8</b>	10.9	5.5%
5	Нүүрсний чанар муудсанаас	2.5	<b>42.0</b>	39.5	4.9%
6	ПСУ доголдож	53.8	<b>31.6</b>	-22.2	3.7%
7	Дөл дэмжихэд	20.1	<b>31.1</b>	10.9	3.6%
8	Зуух зогсооход	25.2	<b>29.3</b>	4.1	3.4%
9	Горим тохируулга	12.4	<b>26.8</b>	14.4	3.1%
10	Нүүрсний чанар	5.0	<b>8.6</b>	3.6	1.0%
11	Уурын шугамд залгаагүй	5.0	<b>4.4</b>	-0.6	0.5%
12	ДМ, ДВ доголдож	0.0	<b>0.6</b>	0.6	0.1%
13	Хэмжүүрээс	1.4	-	-1.4	-
14	Засварын цехээс	3.9	-	-3.9	-
15	Цахилгааны гэмтэл	11.6	-	-11.6	-
16	Нийт зарцуулсан мазут	871.2	<b>863.5</b>	-7.6	100.0%

Солярка зарцуулалтын хэмжээг төлөвлөгөө болон өмнөх онтой харьцуулан дараах хүснэгт №12-д харууллаа.

Хүснэгт 12

Үзүүлэлт	Нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төл-гүйц	гүйц-өм.он
Солярка зарцуулалт	тонн	23847	29700	18099	-11601	-5748

Бургилах давхаргатай зуухны галлагаанд 18099л солярка зарцуулсан нь анхны төлөвлөгөөнөөс 11601 л, өмнөх оноос 5748 л-ээр тус тус буурсан байна. Үүнд зуух №3, 4-ын хүйтэн байдлаас галласан тоо өмнөх оны мөн үеэс 1 удаагаар буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

### 2.1.3 Жишмэл түлш

Нэгж эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 317.42 гр/кВтц, дулаанд 175.83 кг/Гкал байгаа нь анхны төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 8.22 гр/кВтц-аар нэмэгдэж, дулаанд 0.01 кг/Гкал-аар буурсан байна.

Жишмэл түлшний хувийн зарцуулалтын хэмжээг төлөвлөгөө болон өмнөх онтой харьцуулан хүснэгт №13-д харууллаа.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт	Нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	гүйц- төл	гүйц-өм.он
Цахилгаанд	гр/кВтц	308.30	309.2	317.42	8.22	9.12
Дулаанд	кг/Гкал	175.46	175.84	175.83	-0.01	0.37

Жишмэл түлшний хувийн зарцуулалт өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

1. ТГ №9-ын их засварын ажил:

ТГ №9-ыг 2014 онд ашиглалтанд оруулснаас хойш 4 жилийн дараа буюу 2018 онд их засварын ажил хийсэн. Их засварын ажлыг V/06-ны өдрөөс VI/26-ны өдөр хүртэл 50 хоногийн хугацаанд хийхээр төлөвлөсөн боловч тухайн үеийн засварын ажлын эзэлхүүний өөрчлөлт, туршилт тохируулгын ажил зэргээс шалтгаалан 12 хоногоор сунгагдсан. Үүнтэй холбоотойгоор нэгжийн хүчин чадал өндөртэй, эдийн засгийн үр ашигтай турбингенератор удаан хугацаанд засварт зогссон нь жишмэл түлшний хувийн зарцуулалт нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

2. ТБЭХС-ийн хэрэглээний өсөлт:

ТГ №9-ын их засварын ажлын хугацаанд буюу 06-р сард ДДС-ыг 2 зуух, 2 турбингенератортой ажиллахаар төлөвлөсөн боловч ТБЭХС-ийн хэрэглээний өсөлттэй холбоотойгоор тус сард 3 зуух, 3 турбингенератор ажилласан.

Тус сарын үндсэн тоноглолын ажилласан цаг болон жишмэл түлшний хувийн зарцуулалтыг төлөвлөгөө болон өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан хүснэгт №14-д харууллаа.

Хүснэгт №14

Үзүүлэлт			2017-06 сар		2018-06 сар		Зөрүү	
			гүйц	төл	гүйц	гүйц-төл	гүйц-өм.он	
ЦЭХ боловсруулалт		сая кВтц	42.8	51.6	<b>55.7</b>	4.1	12.9	
Дулааны горимоор боловсруулсан ЦЭХ		сая кВтц	18.6	-	<b>19.6</b>	-	1.0	
		%	43.4%		<b>35.2%</b>	-	<b>-8.2%</b>	
ӨДС	С-50-8.83/0.294 ТГ-ын ажилласан цаг	Цаг	368	120	<b>0</b>	<b>-120</b>	-368	
	ПТ-25-90/10М ТГ-ын ажилласан цаг	Цаг	1233	1656	<b>1724</b>	<b>68</b>	491	
	БКЗ-220-100-4С зуухны ажилласан цаг	Цаг	1599	1680	<b>1668</b>	-12	69	
ДДС	ПТ-12-35/10М ТГ-ын ажилласан цаг	Цаг	-	1440	<b>2093</b>	<b>653</b>	<b>2093</b>	
	БКЗ-75-39ФБ зуухны ажилласан цаг	Цаг	-	1440	<b>2093</b>	<b>653</b>	<b>2093</b>	
ЖТХЗ	Цахилгаанд	гр/кВтц	469.7	478	<b>556.1</b>	<b>78.1</b>	<b>86.4</b>	
	Дулаанд	кг/Гкал	183.5	183.8	<b>186.5</b>	<b>2.7</b>	<b>3.0</b>	

Мөн ДҮТ ХХК-ийн шийдвэрээр ТГ №9-ын ЦЭХ-ний үйлдвэрлэлийг нөхөх зорилгоор өндөр даралтын станц VI/28-30-нд ПТ-25-90/10М маркын ТГ №7, 8-ыг нэмж ажилд залган 4 ТГ, 3 зуухны горимоор ажилласан.

Үйлдвэрийн уурын хэрэглээг үл тооцвол конденсацийн горимоор ажилладаг зуны бага ачааллын хугацаанд олон тоноглолыг зэрэг ажиллуулсан нь хөргөх цамхаг болон бризгальны ачааллыг нэмэгдүүлж, конденсаторын вакуум буурах, дундаж ачаалал буурах,

дулааны горимоор боловсруулах ЦЭХ-ийг бууруулах зэрэг техник эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд шууд сөргөөр нөлөөлж жишмэл түлшний хувийн зарцуулалтын тус сард ихээхэн нэмэгдүүлсэн.

### 3. Дулааны горимоор боловсруулсан ЦЭХ-ний бууралт (ДЭХ түгээлтээс хамаарсан):

Дулааны эрчим хүч түгээлтийн хэмжээ төлөвлөгөөнөөс буурснаар турбины уурын хувийн зарцуулалт буурч 1533.8 тн жишмэл түлш хэмнэсэн боловч, дулааны горимоор боловсруулсан ЦЭХ-ний бууралтаас 4428.7 тн жишмэл түлш хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 15

Үзүүлэлт	Нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он төл	2018 он гүйцэтгэл
ЦЭХ-ний боловсруулалт	сая кВтц	1077.7	1036.5	1085.0
Дулааны горимоор боловсруулах ЦЭХ	сая кВтц	640.7	602.6+13.9	602.6
	%	59.5%	59.5%	55.5%
ДЭХ түгээлт	мян.Гкал	2163.0	2279.1	2192.7

А. Турбины дулаацуулгын отборын ачаалал багатай ажилладаг 03-аас 10-р саруудын хооронд усаар түгээх дулааны эрчим хүчний хэмжээ төлөвлөгөөнөөс 38930 Гкал-аар буурсан байна. Энэхүү дулааны эрчим хүчийг турбины дулаацуулгын отбороос түгээгээгүйгээс дулааны горимоор боловсруулах цахилгаан эрчим хүчний хэмжээ 13.9 сая кВтц-аар буюу 4.0%-аар буурсан байна. Нөгөө талаас 3672.6 тонн жишмэл түлшний дулааныг усаар түгээх дулааны эрчим хүч буурснаас шалтгаалан хөргөх цамхагт алдсан байна.

Б. Сүлжээний шууд усны халууны хэмжээ төлөвлөгөөнөөс 4.4 °С-ээр, өмнөх оноос 0.9°С-ээр нэмэгдсэн. Энэ нь туслах бойлсрийн халаагч уур буюу үйлдвэрийн отборын ачаалал болон бууруулан хөргөх төхөөрөмжийн ачааллыг нэмэгдүүлж байна. Турбингенераторын үйлдвэрийн отбор, дулаацуулгын отбороос илүү ачааллагдах нь дулааны горимоор боловсруулах ЦЭХ-ийг бууруулж байна.

### 4. Турбингенератор №5-ын тохируулгатай отбор ашиглалтын бууралт:

Турбингенератор №5-ын холхивчийн доргио цахилгаан дулааны ачаалалтай шууд хамааралтайгаар нэмэгдэж байгаагаас шалтгаалан 01, 02-р саруудад дундаж цахилгаан ачаалал 19.5 МВт.ц, тохируулгатай отборын дулааны ачаалал 42.2 Гкал.ц-аар ажилласан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тохируулгатай отборын дулааны ачаалал 8.3 Гкал/ц-аар буурсан байна.

Хүснэгт №16

Үзүүлэлт	Нэгж	2017 он эх 2 сар	2018 он эх 2 сар	зөрүү
Ажилласан цаг	цаг	1031	1229	198
ЦЭХ-ний дундаж ачаалал	МВт	22.3	19.4	-2.9
Үйлдвэрийн авлагын ачаалал	тн/ц	74.3	65.5	-8.8
ДЭХ түгээлт	мян.Гкал	683.4	676.8	-6.6
РОУ-ын зарцуулалт	тонн	52240	70110	17870

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны мөн үеэс ДЭХ түгээлтийн хэмжээ 6.6 мянган Гкал-аар буурсан боловч БХТ-ийн зарцуулалт 17870 тонноор нэмэгдсэн байна. Тус хугацаанд бүх турбины тохируулгатай отбор дээд хэмжээнд хүрч, БХТ-өөр нэмэлт ачааллыг авдаг бөгөөд энэ үед турбингенератор №5-ын үйлдвэрлийн отборын ачаалал 8.8 тонн/цаг-аар буурсан нь БХТ-ийн ачааллыг шууд нэмэгдүүлсэн байна. Турбингенератор №5-ын дутуу ачааллыг нөхөхөд БХТ-өөр 10815 тонн уурыг авсан ба энэхүү уурыг турбинээр дамжуулан турбины



8-р үе хүртэл ажил хийсэн тохиолдолд 1.2 сая кВтц ЦЭХ-ийг үйлдвэрлэх боломжтой байв. Энэхүү эрчим хүчийг жишмэл түлшинд шилжүүлбэл 265.5 тонн жишмэл түлштэй тэнцэхээр байна.

#### 2.1.4 ДХЦЭХ

ДХЦЭХ-ний хэмжээ 2018 онд 179.5 сая кВт.ц буюу 16.54% байгаа нь төлөвлөгөөт хэмжээнээс 0.36%-аар буурсан байна.

Хүснэгт №17

Үзүүлэлт	Нэгж	2017 оны гүйц	2018 он		Зөрүү	
			Төл	Гүйц	Гүйц-төл	Гүйц-өм.он
Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч	Сая кВт.ц	175.8	175.2	179.5	4.3	3.7
	Хувь	16.31%	16.90%	16.54%	-0.36%	0.23%

ДХЦЭХ-ний хэрэглээг тоноглол бүрээр дараах хүснэгтэнд харууллаа.

мян.кВтц

Д/д	Тоноглол	2017	2018	Зөрүү
1	Түлш дамжуулахад	3248.0	3375.0	127
2	Тоос бэлтгэлд	53240.1	53991.8	751.7
3	Үлээлт соролтонд	29693.1	29475.1	-218
4	Тунгаах усны байгууламжид	2067.6	2931.3	863.7
5	Багерийн насос	1847.8	2156.9	309.1
6	Мазутын насос	910.7	891.7	-19
7	Тэжээлийн насос	37387.1	38888.2	1501.1
8	Сүлжээний насос	13463.3	14673.6	1210.3
9	Эргэлтийн усны насос	12635.7	12373.7	-262
10	Турбины конденсат насос	3292.4	3411.3	118.9
11	Дулааны ДХ-ний байгууламжид	1145.1	1195.4	50.3
12	Техникийн усанд	6881.1	7270.5	389.4
13	Бусад	9958.4	8880.2	-1078.2
14	Нийт ДХЦЭХ	175770.2	179514.6	3744.4
15	ДХЦЭХ хувь	16.3%	16.5%	0.2%
16	ЦЭХ боловсруулалт	1077697.9	1085033.9	7336

Дээрх хүснэгтээс харахад цахилгаан эрчим хүчний боловсруулалт 7.3 сая кВтц-аар, ДЭХ түгээлтийн хэмжээ 29.7 мян.Гкал-аар нэмэгдсэн нь тоноглолын ажилласан цаг, дундаж ачааллыг нэмэгдүүлснээр тоноглолын бүрийн дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний биет хэмжээ нэмэгдсэн нь харагдаж байна.

Харин тоноглолын ажилласан цаг, дундаж ачаалал нэмэгдсэн боловч үлээлт соролтонд зарцуулах ЦЭХ-ний хэрэглээ буурахад зуух №11-ын ДВ Б болон утаа сорогчийн хөдөлгүүрийн инверторыг ажилд оруулсан нь нөлөөлсөн байна. Тус зууханд 2018 оны 6-аас 12-р сард дээрх тоноглолын хөдөлгүүр инвертортой ажилласнаар 448.4 мян.кВтц-ын хэмнэлт гарсан байна.

Мөн эргэлтийн усны насосны цахилгаан хэрэглээ биетээр 262 мян.кВтц-аар буурсан байна. Үүнд: ТГ №5-8-ын эргэлтийн усны насосны цахилгаан хэрэглээ дунджаар 140 кВтц орчим, ТГ №9-ын эргэлтийн усны насосны цахилгаан хэрэглээ дунджаар 630 кВтц орчим байна. ТГ №9-ын их засварын хугацаанд буюу 62 хоногт ТГ №9-ын оронд ПТ-25-90/10М ТГ-ын 2 насос ажилласан гэж тооцоход ДХЦЭХ-ний хэмжээ биетээр 520.8 мян.кВтц-аар буурсан байна.

- Төлөвлөгөөт хэмжээнээс ДХЦЭХ-ний хувь хэмжээ 0.36%-аар буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

1. ДҮТ ХХК-аас өгөгдсөн графикийн дагуу тус онд төлөвлөгөөнөөс 7.3 сая кВтц ЦЭХ илүү түгээсэн байна.
2. ДЭХ түгээлтийн хэмжээ 86.4 мянган Гкал-аар буурсан.
3. Дээр дурьдсанчлан зуух №11-ын ДВ Б болон ДМ-ын хөдөлгүүрийн инверторыг 06-р сараас ажилд оруулсан.
4. Өндөр даралтын станцын тэжээлийн усны хувьсах зарцуулалтын насосны ашиглалтын хугацаа нэмэгдсэн. Тус насос 2018 онд 6764 цаг ажилласан нь өмнөх оноос 215 цагаар нэмэгдсэн байна.

- Өмнөх оноос ДХЦЭХ-ний хувь хэмжээ 0.23%-аар өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

1. ТГ №9-д их засварыг 62 хоногийн хугацаанд хийсэн бөгөөд тус хугацаанд ДДС-д 3 зуух, 3 турбингенератор ажиллуулсан. Энэ нь нэгжийн хүчин чадал багатай олон тоноглол ажиллаж ДХЦЭХ-ний хэмжээг нэмэгдүүлсэн.
2. ДЭХ түгээлтийн хэмжээ өмнөх оноос 29.7 мянган Гкал-аар нэмэгдсэн.

#### **2.1.4 Уур, ус конденсатын алдагдал**

2018 онд дунджаар 4.6 гүний худаг ажиллан, насос станцаар дамжуулан 7503.7 мянган тонн техникийн ус хэрэглэсэн нь өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 340.2 мянган тонноор, төлөвлөгөөтэй харьцуулахад 496.3 мянган тонноор тус тус буурсан байна.

Конденсатын алдагдал 8.17% буюу 583.5 мян.тонн байгаа нь төлөвлөгөөнөөс 0.83%-аар, өмнөх оноос 0.49%-аар тус тус буурсан байна.

Техникийн усны хэрэглээ болон конденсатын алдагдал буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

- Конденсатын алдагдал төлөвлөгөөт хэмжээнээс 0.8% буюу 57.7 мян.тонноор буурсан.
- Сүлжээний нэмэлт ус төлөвлөгөөт хэмжээнээс 14.4 мян.тонноор буурсан
- Дотоод хэрэгцээний байгууламжийн халаагч уурыг ДДС-аас хангаж ажилласан. ДДС-ын хими ус бэлтгэлийн системийн хаягдал усны хувь хэмжээ ӨДС-аас 39%-аар бага байдаг. Үүнээс шалтгаалан техникийн усны алдагдлыг 43.9 мянган тонноор бууруулсан байна.
- ӨДС-ын түүхий уснаас тэжээгдэх галын усны шугамын схемд өөрчлөлт хийж зарцуулалтын хэмжүүр суурилуулсан ба үүний дүнд хэрэглээг тооцох боломж бий болгосон. Хэмжүүр суурилуулснаас хойш техникийн уснаас 151,4 мян.тонн технологийн усыг галын усанд ашигласныг тодорхойлоод байна.
- Уур, ус, конденсатын алдагдлыг бууруулах чиглэлээр тогтмол эргэлт шалтгалт хийх, алдагдлаа илрүүлье сэдэвт уралдаан зохион байгуулсан зэрэг нь техникийн усны хэрэглээг бууруулахад гол нөлөө үзүүлсэн байна.
- Станцын бүрэн зогсолтоор хийгдэх ажлын эзэлхүүнд уур, усны алдагдлыг нэмэгдүүлж байгаа гэмтлүүдийн жагсаалт гарган тусгуулж устгуулах, засварыг чанартай хийлгэх арга хэмжээ авч ажилласан.



## 2.1.5 Бууруулан хөргөх төхөөрөмжийн ачаалал

Бууруулан хөргөх төхөөрөмжөөр 187.1 мянган тонн уураар 102.9 мянган Гкал дулааны эрчим хүчийг түгээсэн байна. Бууруулан хөргөх төхөөрөмжийн ачааллыг өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт №19

Үзүүлэлт	Нэгж	2017 он	2018 он	зөрүү	
ДЭХ түгээлт	мян.Гкал	2163.0	2192.7	29.7	
РОУ	Зарцуулалт	мян.тн	101.0	187.1	86.1
	Дулаан	мян.Гкал	55.5	102.9	47.4

ДЭХ түгээлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 29.7 мянган Гкал-аар нэмэгдсэн боловч бууруулан хөргөх төхөөрөмжийн дулааны ачаалал 47.4 мянган Гкал буюу нийт ДЭХ түгээлтийн өсөлтөөс 17.7 мянган Гкал-аар нэмэгдсэн байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

1. ТГ №5-ын тохируулгатай отбор ашиглалтын хэмжээ буурсан.

Турбингенератор №5-ын холхивчийн доргио цахилгаан дулааны ачаалалтай шууд хамааралтайгаар нэмэгдэж байгаагаас шалтгаалан 01, 02-р саруудад дундаж цахилгаан ачаалал 19.5 МВт.ц, тохируулгатай отборын дулааны ачаалал 42.2 Гкал.ц-аар ажилласан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тохируулгатай отборын дулааны ачаалал 8.3 Гкал/ц-аар буурсан байна. Энэ талаар дэлгэрэнгүйг жишмэл түлшний хувийн зарцуулалтын хэсэг (2.1.3)-т үзүүлсэн.

2. Сүлжээний усны шууд усны халууны хэмжээ нэмэгдсэн.

ДҮТ ХХК-аас өгсөн диспетчерийн графикийн дагуу дунджаар шууд усны халууныг 102.4°C-ээр барьж ажилласан нь төлөвлөгөөнөөс 4.4°C-ээр, өмнөх оны мөн үеэс 0.9°C-ээр тус тус нэмэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор туслах бойлерийн ачаалал нэмэгдсэн нь бууруулан хөргөх төхөөрөмжийн ачааллыг нэмэгдүүлсэн.

## 3. ҮНДСЭН ТОНОГЛОЛЫН АЖИЛЛАГАА

### 3.1.Зуухны ажиллагаа

2018 онд дунд даралтын хэсэгт 3.3 зуух, өндөр даралтын хэсэгт 4.0 зуух ажиллаж 4209.4 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн. Зуухны ажиллагааны үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтэнд харууллаа.

№	Зуух	Дундаж ачаалал			Хурц уурын		Ажилласан цаг	Галласан тоо		Мазут зарцуулалт	Солярка зарцуулалт	Зуухны зогсолт	Ашигт үйлийн коэффициент бохирдоор
		Дундаж ачаалал	Бүтэн	Хагас	Даралт	Халуун		Хүйтэн байдлаас	Халуун байдлаас				
Дунд даралтын станц	К-1	60.9			37.6	439	5663	4	2	39.9		6	88.9
	К-2	64.4			38.7	439	4324	4	1	53.1		5	88.4
	К-3	65.3			37.7	431	4482	3	1		8553	4	90
	К-4	67.8			37.4	438	4335	4	2		9546	6	89.5
	К-5	63.6			37.5	436	5736	4	3	52.5		7	88.8
	К-6	60.4			37.7	439	3952	3		22.8		3	87.9
	ДДХ	<b>63.6</b>			<b>37.7</b>	<b>437</b>	<b>28492</b>	<b>22</b>	<b>9</b>	<b>168.3</b>	<b>18099</b>	<b>31</b>	<b>88.9</b>
	2017 он	63.3			37.9	438	26993	28	3	188.6	23847	31	88.9
Өндөр даралтын станц	К-7	125	151	84.0	95.8	534	6062	6	2	135.7		7	88.8
	К-8	139	158	81.9	95.6	533	3531	2	1	80.8		3	88.6
	К-9	156	156		99.0	530	4616	3	1	71.7		4	90.7
	К-10	152	152		96.6	531	5314	6	1	112.3		6	89.9
	К-11	148	158	88.6	97.8	532	6378	4	4	127.8		8	89.1
	К-12	148	148		95.8	531	4498	4	2	77.2		7	89.8
	К-13	158	162	97.2	98.3	534	5066	4	2	89.8		6	89.2
	ӨДХ	<b>146</b>	<b>155</b>	<b>85.5</b>	<b>97.0</b>	<b>532</b>	<b>35465</b>	<b>29</b>	<b>13</b>	<b>695.3</b>		<b>41</b>	<b>89.5</b>
	2017 он	151	156	88.6	97.4	532	34479	32	10	682.5		42	89.3

- ✓ Дээрх хүснэгтээс харахад ДДС-ыг 6-р сард ажиллуулсан нь өмнөх оноос ажилласан цаг 1499 цагаар нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
- ✓ ДДЗ-ны хүйтэн галлагааны тоо 6 удаагаар буурсан нь мазут зарцуулалт 20.3 тонноор буурахад гол нолоо үзүүлсэн.
- ✓ Өндөр даралтын зуухны дундаж ачаалал өмнөх оноос 5 тн/ц-аар буурахад тал зуухны горимоор ажилласан цаг нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Тус онд тал зуухны горимоор 4751 цаг ажилласан нь өмнөх оноос 70.3% буюу 1962 цагаар нэмэгдсэн байна.

### 3.2. Турбингенераторын ажиллагаа

2018 онд дунд даралтын хэсэгт 2.5 турбингенератор, өндөр даралтын хэсэгт 3.7 турбингенератор ажиллаж 1085.0 сая.кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн. Турбингенераторын ажиллагааны үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтэнд харууллаа.

Турбин	Ажилласан цаг	Дундаж цахилгаан ачаалал	Зогсоосон тоо	Явуулсан тоо	Вакуум	уурын хувийн зарцуулалт	Тэжээлийн усны халуун	Суурилагдсан хүчин чадал ашиглалт
Нэгж	Цаг	МВт	-	-	%	кг/кВт	°С	%
ТГ-1	6353	9.1	5	5	90.5	8.7	141.8	55.1%
ТГ-2	6310	9.5	6	6	88.5	7.7	144.5	57.3%
ТГ-3	2593	9.5	6	6	93.4	8.9	140.8	23.5%
ТГ-4	6368	9.3	2	2	88.4	8.5	145.8	56.6%
<b>ДДХ</b>	<b>21624</b>	<b>9.4</b>	<b>19</b>	<b>19</b>	<b>89.6</b>	<b>8.4</b>	<b>142.8</b>	<b>48.1%</b>
2017 он	19615	10.1	12	11	92.9	8.3	144.3	46.9%
ТГ-5	7644	20.7	8	9	94.0	6.4	207.8	82.1
ТГ-6	5876	21.9	7	7	93.1	6.4	210.3	66.8
ТГ-7	7318	22.2	8	8	93.5	6.5	212.2	84.2
ТГ-8	3941	21.3	4	4	89.1	6.7	214.4	43.5
ТГ-9	7290	48.0	6	6	92.4	4.4	213.8	79.9
<b>ӨДХ</b>	<b>32069</b>	<b>21.5/48.0</b>	<b>33</b>	<b>34</b>	<b>92.8</b>	<b>5.7</b>	<b>209.0</b>	<b>73.0%</b>
2017 он	31357	21.1/47.7	35	35	90.0	5.7	210.4	72.8%

Дээрх хүснэгтээс харахад ДДС турбингенераторын дундаж ачаалал 0.7 МВт-аар буурсан байна. Үүнд ТГ №9-ын их засвартай холбоотойгоор ДДС нь 06-р сард конденсацгийн горимоор 3 турбингенератор 8.8 МВт-ын дундаж ачаалалтайгаар ажилласан.

Зогсолтын тоо 7 удаагаар, явалтын тоо 8 удаагаар нэмэгдсэн. Үүний тайлбарыг үндсэн тоноглолын зогсолтын хэсэгт оруулсан болно.

ДЭХ түгээлтийн хэмжээ ДДС-д 22.7 мянган Гкал-аар нэмэгдсэн нь ТГ-ын ЦЭХ боловсруулахад зарцуулах уурын хувийн зарцуулалт нэмэгдэх, тэжээлийн усны халуун буурах зэрэгт гол нөлөө үзүүлсэн.

ТГ №3 болон ТГ №8-д их засварын ажил хийсэнтэй холбоотойгоор тус турбингенераторуудын суурилагдсан хүчин чадал ашиглалтын хэмжээ буурсан байна.


#### 4. Үндсэн тоноглолын зогсолт

2018 онд зуух 72 удаа, турбин 52 удаа зогссон нь өмнөх оноос зуухны зогсолтын тоо 1 удаагаар буурч, турбины зогсолтын тоо 5 удаагаар нэмэгдсэн байна.

Үзүүлэлт		2017 гүйц	2018 төл	2018 гүйц	Зөрүү гүйц-төл	Зөрүү гүйц-өм.он
Зогсолтын тоо	Зуух	73	72	72	0	-1
	Турбин	47	44	52	8	5
	Нийт	120	116	124	8	4
Аваарын зогсолтын тоо	Зуух	21	-	21	-	0
	Турбин	10	-	18	-	8
	Нийт	31	-	39	-	8

Мөн аваарын зогсолтын тоо төлөвлөгөөнөөс турбины хувьд 8 удаагаар нэмэгдсэн байна. Зуухын зогсолтын тоо төлөвлөгөөт хэмжээнд буюу өмнөх оноос 1 удаагаар буурсан байна.

Үндсэн тоноглолын зогсолтын 31.5% нь аваарийн зогсолт, 46.0% нь гэмтэл устгах, 22.5% нь бэлтгэлд зогссон байна.



Дээрх хүснэгтээс харахад зуухны зогсолтын тоо төлөвлөгөөт хэмжээнд, турбины зогсолтын тоо төлөвлөгөөнөөс 8 удаагаар нэмэгдсэн байна.

Турбины зогсолтыг ДДТ болон ӨДТ цехээр дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт №23

Үзүүлэлт		2017 гүйц	2018 төл	2018 гүйц	Зөрүү гүйц-төл	Зөрүү гүйц-өм.он
ДДТ	Нийт зогсолт	12	12	19	7	7
	Аваарын зогсолт	4	-	5	-	1
ӨДТ	Нийт зогсолт	35	32	33	1	-2
	Аваарын зогсолт	6	-	12	-	6

ДДТ цехийн зогсолтын тоо 7 удаагаар нэмэгдсэн байна. Үүнд ТГ №3-ыг их засвараас явуулах, гэмтэл устгах зогсолт олон удаа хийгдсэн нь нөлөөлсөн байна.

ТГ №3-ын их засварын дараах гэмтэл устгалтаас шалтгаалсан бусад ТГ-ын явалт, зогсолтын тоог дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт №24

ТГ №3 явалт	Явалтын шалтгаан
IX/26	Их засвараас явуулж ТГ №2 бэлтгэлд зогсоов.
X/18	Их засварын дараах гэмтэл устган явуулж, ТГ №2 бэлтгэлд зогсоов.
XI/14	Тохируулгын бүлэг клапаны гэмтэл устган явуулж, ТГ №2 бэлтгэлд зогсоов.

Хүснэгт №25

ТГ №3 зогсолт	Зогсолтын шалтгаан
X/04	Их засварын дараах гэмтэл устгахаар зогсоож, ТГ №4 явуулав.
X/31	Тохируулгын бүлэг клапны гэмтэл устгахаар зогсоож, ТГ №2 явуулав.
XII/03	Гэмтэл устгалтаар зогсоож, ТГ №2-ын явуулав.

2017 онд ТГ №2 их засвар хийгдсэн бөгөөд их засварын дараах гэмтэл устгалтаар 1 удаа зогссон. ТГ №3 2018 онд их засвар хийгдэж, их засварын дараах гэмтэл устгалтаас шалтгаалан ТГ №3 3 удаа, ТГ №2 2 удаа, ТГ №4 -ыг 1 удаа буюу ТГ №3-аас шалтгаалан нийт 6 удаагийн зогсолт гарсан нь нийт явалт зогсолтын тоо өсөхөд нөлөөлсөн байна.

Турбины аваарын зогсолт өмнөх оноос 6 удаагаар нэмэгдсэн байна. Үүнд 2018.09.15-ны өдөр системийн хүчдэлийн савлалтаас шалтгаалан 5 ТГ, 2018.09.19-ны өдрийн системийн хүчдэлийн савлалтаас шалтгаалан 4 ТГ тус тус аваараар зогссон нь нийт аваарын зогсолтын 50%-ийг эзэлж байна.

Үндсэн тоноглолын зогсолтыг цех тус бүрээр дараах хүснэгт №26÷29-д харууллаа.

■ -Аваар      ■ -Гэмтэл устгалт      ■ -Бэлтгэл

Хүснэгт №26

№	Дунд даралтын зуухны зогсолтын шалтгаан	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	2018 он	2017 он
1	Бэлтгэлд		2		1	3					2			8	2
2	Урсгал засварт													0	7
3	Их засварт					1								1	2
4	Их засварын дараах гэмтэл устгалт											1		1	2
5	Халах гадаргуугийн гэмтэл	1	1		1	1					1			5	7
6	Цахилгааны гэмтэл	1											1	1	3
7	Хамгаалалтаар													0	0
8	Тээрмийн гэмтэл		1	1	1							1		4	5
9	ВВСМ-ын гэмтэл													0	2
10	Системийн хүчдэлийн савлалт									2				2	1
11	Уур хөргөгчийн хаалтны фланц үлээсэн				1									1	1
12	Нүүрс тэжээгчийн удирдлагад гэмтэл		1											1	0
13	ТГ-ын гэмтэл устгалт			1						1				2	
14	Бүрэн зогсолт							3						3	2
15	Нийт	2	5	2	5	4	0	3	0	3	3	2	2	31	-
16	2017 он	1	6	1	2	5	0	0	0	4	2	6	4	-	31

Хүснэгт №27

№	Өндөр даралтын зуухны зогсолтын шалтгаан	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	2018 он	2017 он
1	Бэлтгэлд		1	1		1	1			1		1		6	6
2	Утаа сорогчийн гэмтэл			1										1	
2	Тээрмийн гэмтэл	1	1	1							1			4	1
3	Урсгал засварт		1	1	1	1		1	2	1			1	9	7
4	Их засварт				1									1	1
5	Хүчдэлийн савлалтаас									7				7	2
6	Халах гадаргуугийн гэмтэл	1							1				1	3	9
7	Тэж. усны хаалтны гэмтэл устгах								1	1				2	1
8	Цахилгааны гэмтэл			1										1	1
9	110 кВ ИХБ-д богино залгаа үүссэнээс													0	4
10	ТГ №9 110 кВ ИХБ-д нум үүссэнээс													0	4
11	ТГ №7 генераторын хөргөлтийн шугамын үлээлт устгахаар						1							1	1
12	Бүрэн зогсолт						3							3	3
13	Трансформаторын тэжээлийн кабелийн гэмтлээс (ТП-4)									1				1	1
14	Насоо станцын шугамын гэмтлээс													0	1
15	Хаалт, арматурын гэмтэл										1			1	2
16	Хүйтэн тэжээгч №1 хаалтны гэмтэл устгах											1		1	
